ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: 2024/294/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Релаэнс секюритиз Аудит” ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт......................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга...................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.............................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ............................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан.................................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл...................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ......................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.........................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ......................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................................
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл................................................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/138.
танай ______________-ны № ___________________-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.МАРТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 98,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **105,805,386.91** | **174,473,712.53** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 26,097,618.47 | 92,592,666.82 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 26,097,618.47 | 92,592,666.82 |
| **3121** | **Төгрөг** | 26,097,618.47 | 92,592,666.82 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 72,727.79 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 72,727.79 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 72,727.79 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 79,707,768.44 | 81,808,317.92 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,875,600.00 | 2,875,600.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,695,600.00 | 2,695,600.00 |
| 35130 | Эм боох материал | 180,000.00 | 180,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,832,168.44 | 78,932,717.92 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,252,962.00 | 1,140,162.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,029,775.00 | 6,939,875.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,124,850.00 | 1,183,880.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 62,424,581.44 | 69,668,800.92 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,145,469,027.96** | **1,227,675,323.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,145,469,027.96 | 1,227,675,323.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,096,359,027.96 | 1,178,154,656.40 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,180,114,409.97 | 1,180,114,409.97 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -145,802,119.52 | -114,109,820.20 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 62,890,413.00 | 71,870,313.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -34,898,977.51 | -27,711,045.53 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,753,474.36 | 48,259,641.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -23,400,472.34 | -9,576,922.93 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 00.00 | 28,882,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -276,220.01 |
| 39217 | Ном | 702,300.00 | 702,300.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 49,110,000.00 | 49,520,666.64 |
| 39301 | Програм хангамж | 00.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -29,333.36 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,110,000.00 | 49,110,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,251,274,414.87** | **1,402,149,035.57** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,251,274,414.87** | **1,402,149,035.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,251,274,414.87 | 1,402,149,035.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 245,410,654.36 | 245,410,654.36 |
| 51101 | Өмч: - төрийн | 245,410,654.36 | 245,410,654.36 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 932,555,618.17 | 1,068,832,739.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 932,555,618.17 | 998,486,305.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 70,346,433.58 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 73,308,142.34 | 87,905,641.86 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,251,274,414.87** | **1,402,149,035.57** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,078,522,908.98** | **885,855,847.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,277,805,708.98** | **76,358,547.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,277,805,708.98 | 76,358,547.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,277,805,708.98 | 76,358,547.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,277,805,708.98 | 76,358,547.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **800,717,200.00** | **809,497,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 595,103,100.00 | 716,435,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 595,103,100.00 | 716,435,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 105,548,300.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 975,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 104,573,300.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 100,065,800.00 | 93,061,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 100,065,800.00 | 93,061,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **827,248,494.11** | **815,509,413.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **827,248,494.11** | **815,509,413.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 718,171,165.08 | 801,582,713.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 436,985,731.87 | 476,928,422.01 |
| 210101 | Үндсэн цалин | 324,401,416.23 | 349,477,547.80 |
| 210102 | Нэмэгдэл | 90,974,741.47 | 113,864,081.03 |
| 210104 | Урамшуулал | 21,609,574.17 | 13,586,793.18 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,075,520.92 | 62,288,729.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,830,651.13 | 42,725,477.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,450,664.41 | 5,010,970.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,526,931.80 | 3,917,293.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 835,518.04 | 961,800.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,431,755.54 | 9,673,188.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,880,899.71 | 83,196,172.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,140,726.81 | 9,267,272.06 |
| 210302 | Түлш, халаалт | 58,708,172.90 | 73,928,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,846,837.00 | 6,104,557.52 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,846,837.00 | 6,104,557.52 |
| **2105** | **Нормативт зардал** | 80,560,380.00 | 83,405,870.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 800,900.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 79,759,480.00 | 83,405,870.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,352,000.00 | 20,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,352,000.00 | 20,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,585,800.00 | 1,425,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,585,800.00 | 1,425,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 72,883,995.58 | 67,733,162.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,425,650.00 | 14,962,280.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,631,200.00 | 2,706,620.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 53,827,145.58 | 50,064,262.04 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 109,077,329.03 | 13,926,700.15 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 104,469,800.00 | 4,561,072.21 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 82,508,800.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 21,961,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 4,561,072.21 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,607,529.03 | 9,365,627.94 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,607,529.03 | 9,365,627.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,251,274,414.87** | **70,346,433.58** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,251,274,414.87** | **70,346,433.58** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **800,717,200.00** | **809,497,300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **800,717,200.00** | **809,497,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 595,103,100.00 | 716,435,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 595,103,100.00 | 716,435,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 105,548,300.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 975,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 104,573,300.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 100,065,800.00 | 93,061,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 100,065,800.00 | 93,061,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **773,739,581.53** | **741,145,551.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **773,739,581.53** | **741,145,551.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **664,662,252.50** | **727,384,461.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 436,985,731.87 | 477,166,759.71 |
| 210101 | Үндсэн цалин | 324,401,416.23 | 349,715,885.50 |
| 210102 | Нэмэгдэл | 90,974,741.47 | 113,864,081.03 |
| 210104 | Урамшуулал | 21,609,574.17 | 13,586,793.18 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,075,520.92 | 62,288,729.74 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,830,651.13 | 42,725,477.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,450,664.41 | 5,010,970.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,526,931.80 | 3,917,293.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 835,518.04 | 961,800.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,431,755.54 | 9,673,188.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,880,899.71 | 83,196,172.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,140,726.81 | 9,267,272.06 |
| 210302 | Түлш, халаалт | 58,708,172.90 | 73,928,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103,500.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 83,259,200.00 | 79,464,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 83,259,200.00 | 79,464,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,585,800.00 | 1,425,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,585,800.00 | 1,425,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,271,600.00 | 23,342,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,551,600.00 | 19,064,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,720,000.00 | 4,277,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **109,077,329.03** | **13,761,090.14** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 104,469,800.00 | 4,395,462.20 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 82,508,800.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 21,961,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 4,395,462.20 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,607,529.03 | 9,365,627.94 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,607,529.03 | 9,365,627.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **26,977,618.47** | **68,351,748.35** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **880,000.00** | **1,856,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **880,000.00** | **1,856,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 880,000.00 | 1,856,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 880,000.00 | 1,856,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-880,000.00** | **-1,856,700.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 26,097,618.47 | 66,495,048.35 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 26,097,618.47 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 26,097,618.47 | 92,592,666.82 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 245,410,654.36 | 73,308,142.34 | 906,846,762.28 | 00.00 | 1,225,565,558.98 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -1,225,565,558.98 | 00.00 | -1,225,565,558.98 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **245,410,654.36** | **73,308,142.34** | **-318,718,796.70** | **00.00** | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,251,274,414.87 | 00.00 | 1,251,274,414.87 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **245,410,654.36** | **73,308,142.34** | **932,555,618.17** | **00.00** | 1,251,274,414.87 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **245,410,654.36** | **73,308,142.34** | **932,555,618.17** | **00.00** | 1,251,274,414.87 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 65,930,687.60 | 00.00 | 65,930,687.60 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **245,410,654.36** | **73,308,142.34** | **998,486,305.77** | **00.00** | 1,317,205,102.47 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 14,597,499.52 | 00.00 | 00.00 | 14,597,499.52 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 70,346,433.58 | 00.00 | 70,346,433.58 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **245,410,654.36** | **87,905,641.86** | **1,068,832,739.35** | **00.00** | 1,402,149,035.57 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 742,533,100.00 | 649,360,451.65 | 87.5 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 742,533,100.00 | 649,360,451.65 | 87.5 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 737,899,300.00 | 644,964,989.45 | 87.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 547,681,600.00 | 477,166,759.71 | 87.1 |
| 210101 | Үндсэн цалин | 363,815,000.00 | 349,715,885.50 | 96.1 |
| 210102 | Нэмэгдэл | 167,748,000.00 | 113,864,081.03 | 67.9 |
| 210104 | Урамшуулал | 16,118,600.00 | 13,586,793.18 | 84.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,460,900.00 | 62,288,729.74 | 91.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,553,100.00 | 42,725,477.38 | 91.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,476,800.00 | 5,010,970.98 | 91.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,381,600.00 | 3,917,293.21 | 89.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,095,600.00 | 961,800.07 | 87.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,953,800.00 | 9,673,188.10 | 88.3 |
| **2105** | **Норматив зардал** | 92,591,400.00 | 79,464,900.00 | 85.8 |
| 210502 | Хоол, хүнс | 92,591,400.00 | 79,464,900.00 | 85.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху** | 1,425,800.00 | 1,425,800.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,425,800.00 | 1,425,800.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27739600.00 | 24618800.00 | 88.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,462,300.00 | 20,341,500.00 | 86.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,277,300.00 | 4,277,300.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4633800.00 | 4395462.20 | 94.9 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,633,800.00 | 4,395,462.20 | 94.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,633,800.00 | 4,395,462.20 | 94.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 648,620,000.00 | 716,435,500.00 | 110.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 648,620,000.00 | 716,435,500.00 | 110.5 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 648,620,000.00 | 716,435,500.00 | 110.5 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 26,097,618.47 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 26,097,618.47 | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын цэцэрлэг нь 2023 оныг "Цэцэрлэгийн хувьд хөрөнгө оруулалтыг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 97,6 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль

тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.
Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

2023 он 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 83,8 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023. оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 281,209.2 мянган төгрөгөөр буюу 8,4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 26,097.6 | 92,592.7 | 66,495.0 |
| **Авлага** | | 72.7 | 72.7 |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 79,707.8 | 81,808.3 | 2,100.5 |
| **Үндсэн хөрөнгө** | 1,145,469.0 | 1,227,675.3 | 82,206.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,251,274.4** | **1,402,149.0** | **150,874.6** |
| **Өр төлбөр** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| **Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/** | 1,177,966.3 | 1,314,243.4 | 136,277.1 |
| **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | 73,308.1 | 87,905.6 | 14,597.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,251,247.4** | **1,402,149.0** | **150,874.6** |

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 66,495.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урд оны төсвийн гүйцэтгэлийн үлдэгдэл, мөнгөн хөрөнгө дансанд орж ирснээс шалтгаалан мөнгөн хөрөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 72.7 мянган төгрөг байгаа нь нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 2,100.5 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар аймгийн Боловсролын газраас 4,356,8 мянган төгрөгийн, эцэг эхчүүдээс 1,919.0 мянган төгрөгийн нийт 6,275.8 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан нь материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна. Мөн цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/19 тоот тушаалаар аж ахуйн материал 1,407.9 мянган төгрөг, хангамжийн материал 4,696.7 мянган төгрөг нийт 6,104.6 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 80,196.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж 836.7 мянган төгрөг, программ хангамж 440.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 580.0 мянган төгрөг, нийт 1,856.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн гадна тоглоомын талбай, хашааг 28,882.0 мянган төгрөгөөр тохижуулж, Хандиваар 2,770.0 мянган төгрөгийн хөрөнгө, Дэлхийн зөн ОУБ-с 14,000.0 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн Засаг даргын тамгын газраас 3,123.9 мянган төгрөгийн нийт 19,893.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлж авсантай холбоотойгоор өссөн байна.

Баянчандмань сумын ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны 01 дүгээр тогтоолоор машин тоног төхөөрөмж данснаас 9,720.3 мянган төгрөг, тавилга эд хогшил данснаас 4,637.6 мянган төгрөг нийт 14,357.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 648,620.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 93,061.8 мянган төгрөг нийт зарлагыг 741,681.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 741,681.8 мянган төгрөгөөр баталсан байна.

.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 741,681.8 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 716,435.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 83,696.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 800,131.6 мянган төгрөг буюу 108,0 хувьтай байгаа нь үндсэн цалин, нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс 17,292.3 мянган төгрөгөөр, хоол хүнс 13,126.5 мянган төгрөгөөр, бусад зардал 3,120.8 мянган төгрөгөөр бүх төрлийн даатгалын зардлаас 6,172.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | 71801-Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 2,138.7 | 1,240.0 | 898,7 | 58% |
| 2 | 81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 92,591.4 | 79,464.9 | 13,126.5 | 85,8% |
| 3 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 5,028.0 | 5,028.0 | | 100% |
| 4 | 81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 2,166.7 | 2,138.7 | 28.0 | 98,7% |
| 5 | 81833 Явуулын багшийн үйлчилгээ | 4,238.9 | 3,446.7 | 837.2 | 80,5% |
| 6 | 81834 Боловсролын стандарт | 471,034.7 | 410,863.1 | 60,171.6 | 87,2% |
| 7 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 165,289.7 | 147,179.0 | 18,110.7 | 89% |
| 8 | 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 93,061.8 | 83,696.2 | 9,365.6 | 89,9% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71801-81605 | 2023-12-31 | Эрүүл мэндийг дэмжих | 58% | 2,138.7 | 1,240.0 |
| 2 | 71801-81807 | 2023-12-31 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 85,8% | 92,591.4 | 79,464.9 |
| 3 | 71801-81816 | 2023-12-31 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 100% | 5,028.0 | 5,028.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **4** | 71801-81823 | 2023-12-31 | Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 98,7% | 2,166.7 | 2,138.7 |
| **5** | 71801-81833 | 2023-12-31 | Явуулын багшийн үйлчилгээ | 80,5% | 4,238.9 | 3,446.7 |
| **6** | 71801-81834 | 2023-12-31 | Боловсролын стандарт | 87,2% | 471,034.7 | 410,863.1 |
| **7** | 71801-81835 | 2023-12-31 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 89% | 165,289.7 | 147,179.0 |
| **8** | 71801-80111 | 2023-12-31 | Тогтмол зардал | 89,9% | 93,061.8 | 83,696.2 |

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Явуулын багшийн үйлчилгээ арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хагас ажилчид урьд онд хамрагдсантай холбоотой.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн,  цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын худалдан авах ажиллагааны газраас тендерт зарласан боловч 1 ч оролцогч оролцоогүй  тул 79,464.9  мянган төгрөгийн хүнсний материал,  Мөнх Оюу ХХК-аас хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх материал шууд худалдан авалтаар худалдан авсан.

Юнител ХХК-с Багш нарт хэрэглэгдэх Дата-г гэрээгээр худалдан авсан. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын цэцэрлэгийн *2023* оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 665,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 13,300.0 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,640.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Баянчандмань сумын хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна.Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 70,515.0 мянган төгрөгөөр
- Норматив зардлыг 13,126.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 1 мэдээлэл хоцроож байршуулсан байна.. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д ”Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил

гүйлгээ", МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д "өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг анхааруулав.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 1,700.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгч ажиллалаа. Завсрын аудитын зөвлөмжийн биелэлтийг жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад зөвлөмж хэрэгжээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| **Акт** | | | | | |
| **Албан шаардлага** | 1 | 51,681.1 | 1 | 51,681.1 | 100 |
| **Зөвлөмж** | 2 | 1,770.1 | 2 | 1,770.1 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **53,451.2** | **3** | **53,451.2** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,700.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,700.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Тухайн байгууллага нь 2023 онд хөдөлмөрийн хөлсийг бодож олгохдоо шөнийн нэмэгдлийг бодож олгоогүй улмаас 1,700.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Хөдөлмөрийн хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Цаашид дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэн, ажилчдын шөнийн нэмэгдлийг тооцож олгож байх

Холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг биелүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шөнийн нэмэгдлийг бодож олгоогүй | | 1 | | | | | | 1 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **1,700,0** | | | | | | **1,700,0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn